

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2023 оны жилийн эцсийн байдлаар)

№	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Хүрсэн түвшин	Гүйцэтгэлийн хувь (хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар)
				Он	Түвшин		
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО							
2.5. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, Нийгмийн даатгалын тогтолцоог шинэчилж, нийгмийн халамжийг оновчтой болгон, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хүн амын хөгжлийг хангаж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлнэ.							
2.5.1.1.	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчлэнэ.	-	Нийгмийн даатгалын багц хууль батлагдсан байна.	2020-2024	Нийгмийн даатгалын эрх зүйн орчинд шинэчлэл хийгдээгүй байна.	Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэлэлцэн баталж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр шийдвэрлэсэн. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэр авахаас гадна, хувийн нэмэлт тэтгэврийн даатгалд сайн дурын үндсэн дээр хамрагдаж нэмэлт тэтгэвэр авч болох эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Мөн Нийгмийн даатгалын шимтгэлийг олон жил төлж ажилласан	100

						<p>даатгуулагч илүү өндөр тэтгэвэр авах шударга тогтолцоонд тулгуурлан даатгуулагчийн 20 жилээс илүү төлсөн жил тутамд дундаж цалин хөлснөөс 2.0 хувиар тооцох, Өндөр насны тэтгэвэр авагч нас барвал түүний авч байсан тэтгэврийн 20 хувиар тооцон нөхөр/эхнэрийн өндөр насны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхээр, тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын түвшинтэй уялдуулан жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэх хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн байна.</p> <p>Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.</p>	
2.5.1.2.	Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	-	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль (шинэчлэгдсэн найруулга) батлагдсан байна.	2020-2024	Иргэд суурь тэтгэвэр олгох эрх зүйн орчин бүрдсэн байна.	Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлж, даатгуулагч санхүүгийн олон эх үүсвэрээс тэтгэвэр авна гэж тусгасан. Үүнд: 1-р давхарга: Тэтгэврийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, 2-р давхарга Хувийн нэмэлт тэтгэвэр /сайн дурын үндсэн дээр/	70
2.5.1.3	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	-	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тухай хууль батлагдсан байна.	2020-2024	Иргэд хувийн тэтгэврийн даатгалд даатгуулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.	Тэтгэврийн тогтолцоог шинэчилж олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх бодлогын хүрээнд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаалаар Нийгмийн даатгалын багц хуулийн үзэл баримтлал, төсөл, танилцуулга бэлтгэх Ажлын хэсгийг холбогдох төрийн болон олон нийтийн байгууллагуудын	70

						төлөөллүүдийг оролцуулан байгуулж, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлснээр Улсын Их Хуралд өргөн барьсан боловч намрын чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.	
2.5.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны үлдэгдлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.							
2.5.2.1.	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх хуулийн заалт батлагдсан байна.	2020-2024	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг гэр бүлд нь өвлүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.	<p>Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц сан бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх”-ээр тусгаж хуульчилсан.</p> <p>Тэтгэврийн хагас хуримтлалын тогтолцоонд шилжих зорилтын хүрээнд нэрийн дансны орлогыг үе шаттайгаар мөнгөжүүлж уг орлогын тодорхой хэсгийг даатгуулагчийн хууль ёсны өв залгамжлагчид нь 2030 оноос эхлэн өвлүүлэхээр зохицуулсан.</p> <p>Хуульд өндөр насны тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагч нас барсан бол түүний нөхөр /эхнэр/-ийн өндөр насны тэтгэврийг нэмэгдүүлнэ, тэтгэврийн нэмэгдлийн хэмжээ нь нас барсан тэтгэвэр авагчийн авч байсан тэтгэврийн 20 хувьтай тэнцүү байна гэж өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалт тусгагдсан. Мөн тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг санхүү, төсвийн, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн</p>	100

						саналыг үндэслэн Засгийн газар батална гэж шинэчлэгдсэн.	
2.5.3. Хуримтлалын нэгдсэн сангаар дамжуулж, иргэн бүрийн боловсрол, эрүүл мэнд, тэтгэвэр, орон сууц, нийгмийн хамгааллын үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэх тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ.							
2.5.3.1	Хуримтлалын нэгдсэн санг бүрдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.		Хуримтлалын нэгдсэн сантай болох хуулийн заалт батлагдсан байна.	2020-2024	Эрх зүйн орчин бүрдсэн байна.	Шинэчлэн баталсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх” гэж тусгасан. 29 дүгээр зүйл 29.3.1-д тэтгэврийн даатгалын шиймтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, сайн дурын даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлогыг “Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх” гэж заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг мөнгөжүүлж нэрийн дансанд байршуулна. Нийгмийн даатгалын хуваарилалтын зарчим /эв санааны/-аас хуримтлалын тогтолцоонд үе шаттайгаар шилжинэ. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаарх баримтлах бодлогын /2015-2030/ баримт бичгийн 3.2.5-д 1979 оны 01 сарын 01-ний өдөр ба түүнээс хойш төрсөн даатгуулагчийн нэрийн дасны орлогыг үе шаттай мөнгөжүүлж хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлнэ. Мөн мөнгөжүүлсэн орлогыг тодорхой хувийг Хуримтлалын нэгдсэн санд байршуулах замаар бодит хуримтлалыг бий болгон эрүүл мэнд, боловсрол, орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрт зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ.	100
2.5.4. Хөдөлмөрийн зах зээлийг орчин үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, бүтээмж, үр дүнд суурилсан цалин хөлс, ажлын үнэлгээний систем нэвтрүүлж, зайнаас болон цагаар ажиллах уян хатан зохицуулалт бий болгон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.							

2.5.4.1.	Хөдөлмөрийн зах зээл, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ.	-	Хуулийн шинэчлэлтэй уялдуулан бусад хууль, тогтоомж, дүрэм журамд өөрчлөлт оруулж батлуулсан байна.	2020-2024	Ажилгүйдлийн даатгалын сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн уялдаа холбоо хангалттай биш.	<p>Монгол Улсын Их Хурлаас 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын багц хуулийг шинэчлэн баталсан. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд Ажил олгогчийн цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос ажилгүйдлийн даатгалын санд төлөх шимтгэлийн 0.2 хувийг 0.5 хувь болгон шинэчлэн баталсан. Мөн ажилгүйдлийн тэтгэмжийг даатгуулагчийн шимтгэл төлсөн хугацааг харгалзан ажилгүй болохын өмнөх шимтгэл төлсөн сүүлийн дараалсан 3 сарыг 9 сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 45, 50 хувиар олгодог байсныг 50, 55 хувь хэмжээгээр тооцож олгохоор болгосон..</p> <p>Мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад ажлын байранд даатгуулагчийг тогтвор суурьшилтай урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх, даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх, зорилгоор ажил олгогчид 5 жилд 1 удаа 10 хувиар шимтгэлийн хөнгөлөлт үзүүлж байсныг сангийн чадавхид үндэслэн 3 жилд нэг удаа 15 хувиар хөнгөлөлт үзүүлэхээр тусган батлуулав. Хууль 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэнээр:</p> <ul style="list-style-type: none"> • Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй • Ажлын байраа хадгалсан, нийгмийн даатгалын ерөнхий хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчид 	100
----------	---	---	---	-----------	--	--	-----

						үзүүлэх шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдэнэ.	
2.5.5. Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийг инфляц, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.							
2.5.5.1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцийн түвшинтэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	-	Инфляцийн түвшинтэй уялдуулан тэтгэврийн хэмжээ нэмэгдсэн байна.	2020-2024	Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500.0 мян төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 400.0 мян төгрөг	Даатгуулагчийн шимтгэл төлөх болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын өнөөгийн үнэ цэнийг тооцох итгэлцүүрийг улсын дундаж цалин, хэрэглээний үнийн өөрчлөлттэй уялдуулан Үндэсний статистикийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тогтоож, дараа жилийн 01 дүгээр сарын 01-нээс мөрдөнө гэж хуульчилсан. Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүрийг шинэчлэн, шинэчлэн баталсан итгэлцүүрээр өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр авч буй 488.8 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн бодож тогтоох ажлыг зохион байгуулав. Уг арга хэмжээний хүрээнд 2023 оны 6 дугаар сарын байдлаар тэтгэвэр авч байсан 488.1 мянган хүнээс 164.6 мянган хүний тэтгэвэр итгэлцүүр хэрэглэснээр дунджаар 188.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Эдгээр иргэдийн тэтгэврийн нэмэгдэлд 2023 онд 200.1 тэрбум төгрөг зарцуулав.	100
2.5.5.2.	Тэтгэврийн зөрүүг ойртуулах зорилгоор тэтгэвэр тооцох итгэлцүүрийг	Улсын төсөв	Тэтгэвэр тооцох итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, тэтгэвэр авагчийн тэтгэвэр нэмэгдэн, тэтгэврийн зөрүү ойртсон байна.		Засгийн газрын тогтоолоор тэтгэвэр бодох цалингийн	Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар тогтоолоор тэтгэвэр бодоход баримтлах цалингийн итгэлцүүрийг шинэчлэн батлав. Шинэчлэн баталсан итгэлцүүрээр өндөр насны, тахир	100

	шинэчлэн тогтооно.				итгэлцүүрийг тогтоосон.	дутуугийн, тэжээгчээ алдсаны болон цэргийн тэтгэвэр авч буй 488.8 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг шинэчлэн бодож тогтоох ажлыг зохион байгуулав. Уг арга хэмжээний хүрээнд 2023 оны 6 дугаар сарын байдлаар тэтгэвэр авч байсан 488.1 мянган хүнээс 164.6 мянган хүний тэтгэвэр итгэлцүүр хэрэглэснээр дунджаар 188.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Эдгээр иргэдийн тэтгэврийн нэмэгдэлд 2023 онд 200.1 тэрбум зарцуулав.	
2.5.6 “Цахим Монгол” арга хэмжээний хүрээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарыг бүхэлд нь цахимжуулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй болгоно.							
2.5.6.1	Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ил тод, түргэн шуурхай, хүртээмжтэй цахим хэлбэрээр хүргэнэ.	Гадаадын зээл тусламж	Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна.		Нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулсан байна.	“Цахим Монгол” арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд иргэд даатгуулагч, ажил олгогч, төрийн болон бусад байгуулагуудад нийгмийн даатгалын үйлчилгээг цаг хугацаа, орон зайн хамааралгүйгээр 24/7 цагийн горимоор цахим хэлбэрээр түргэн шуурхай хүргэх ажлыг өргөжүүлэн ажиллав. Тухайлбал: 1. Даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлтээ, мөн сайн дураар даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад гаргах хугацаа дуусахаас 8 хоногийн өмнө сануулах мэдэгдлийг тухайн даатгуулагчийн гар утасны дугаарт мессежээр илгээх “Message” системийг шинээр нэвтрүүлэв. Даатгуулагч уг мэдэгдлийн дагуу хүсэлтээ E-Mongolia портал, “Даатгуулагчид зориулсан вэб” системийг ашиглан цахимаар илгээх боломжтой бөгөөд эн онд нийтдээ 11.9 мянган даатгуулагчид сануулах мессежийг илгээсэн байна.	90

					<p>2. Монгол Улсын Засгийн Газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд нийт 490.0 гаруй мянган тэтгэвэр авагч “Даатгуулагчид зориулсан вэб” системийг ашиглан 2023 оны 07 дугаар сарын 01-ний тэтгэврийн нэмэгдлийн мэдээлэл, шинэ итгэлцүүрээр өсгөсөн цалингийн мэдээллээ дэлгэрэнгүй харах боломжийг бүрдүүлэв.</p> <p>3. “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль” шинэчлэн батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжихтэй холбогдуулан хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь заалтын дагуу 2019 онд дараалсан 6, 2020-2023 онд дараалсан 7 жилийн цалин хөлсний дунджаас тэтгэврээ тогтоолгосон тэтгэвэр авагч тэтгэврээ 5 жилийн дундаж цалин хөлснөөс өөрчлөн тогтоолгох хүсэлтээ “Даатгуулагчид зориулсан вэб” систем болон E Mongolia порталыг ашиглан цахимаар илгээх боломжийг бүрдүүлэв.</p> <p>4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх ажил олгогч нийгмийн даатгалын байгууллагад биеэр ирэлгүйгээр хүсэлтээ цахимаар илгээх боломжийг бүрдүүлэв.</p> <p>Шинээр 7 сервис боловсруулан Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем болон И-Монгол академи УТҮГ-т хүргүүлэв. Үүнд:</p> <p>Төрийн мэдээлэл солилцооны ХУР системд:</p> <p>1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас “Өрхийн нэгдсэн мэдээллийн сан” үүсгэхтэй холбогдуулан</p>
--	--	--	--	--	---

					<p>даатгуулагчийн цалин, тэтгэврийн мэдээллийн сервис;</p> <p>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн санг үүсгэхтэй холбогдуулан аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулагчдын тоо болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоон мэдээллийн сервис;</p> <p>3. Малчид тариаланчдад төрөөс олгох урамшуулалд зориулсан сайн дурын даатгалын гэрээний мэдээллийн сервис.</p> <p>И-Монгол академи УТҮГ-т:</p> <p>1. Иргэд даатгуулагч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актын батлагдсан маягтаар 22 төрлийн мэдээлэл агуулсан сервис;</p> <p>2. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон актыг англи хэлээр авах сервис;</p> <p>3. ЭХМК-ын хурлаар тогтоолт, сунгалт хийлгэсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхний мэдээлэл дамжуулах сервис;</p> <p>4. 2019-2023 онд дараалсан 6, 7 жилийн цалин хөлсний дунджаас тэтгэврээ тогтоолгосон тэтгэврээр авагч тэтгэврээ нэг удаа өөрчлөн тогтоолгох хүсэлтээ цахимаар илгээх сервис.</p> <p>Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимжуулах ажлыг өргөжүүлснээр 2023 онд дараах үр дүнгүүд гарсан байна. Тухайлбал:</p> <p>- "Нийгмийн даатгал" аппликейшнийг нийтдээ 270.0 мянга орчим иргэн идэвхтэй ашиглаж 22 төрлийн үйлчилгээ, мэдээллийг цахимаар авсан байна.</p> <p>- "Даатгуулагчид зориулсан вэб" системд 1.6 сая орчим удаагийн</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>хандалт хийж 29 төрлийн үйлчилгээг цахимаар авсан байна.</p> <ul style="list-style-type: none"> - Нийт 30.0 мянга даатгуулагч сайн дураар даатгуулах гэрээ байгуулах, хугацаа сунгах, төлбөрөө төлөх үйлчилгээнд онлайнаар хамрагдсан байна. - Давхардсан тоогоор 93.5 мянган ажил олгогч, 2.1 сая даатгуулагч цахимаар хандан QR кодтой шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авсан байна. - Төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаас 114.7 мянган даатгуулагч, ажил олгогч дөрвөн төрлийн лавлагаа, тодорхойлолтоо хэвлэн авсан байна. - НДШ төлөлтийн лавлагаа тодорхойлолтын бодит байдлыг шалгах вэб системээр Элчин сайдын яамдууд, банк, санхүүгийн байгууллагаас 4.5 мянган ажил олгогч, 34.5 мянган даатгуулагчийн шимтгэл төлөлтийн QR кодтой тодорхойлолтыг шалгасан байна. - Идэвхтэй шимтгэл төлж буй 56.8 мянган ажил олгогч сар бүрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангаа 100% цахимаар, үүнээс 23% нь тоон гарын үсгээр баталгаажуулан илгээсэн байна. - “Шимтгэлийн цахим систем”-ээр 3.8 мянган ажил олгогчийн 48.7 мянган тушаалын мэдээллийг цахимаар хүлээн авсан байна. - Нийт 1218 эрүүл мэндийн байгууллагаас 174.9 мянган даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 64.3 мянган даатгуулагч жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн, нийт 239.2 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авсан байна. 	
--	--	--	--	--	--	--

					<p>- “Шимтгэлийн цахим систем”-ээр 16.7 мянган ажил олгогч 144.0 мянган даатгуулагчийн ХЧТА-ны тэтгэмжийн тооцооллыг хийж цахимаар илгээсэн байна.</p> <p>- Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болсон 1.6 мянган даатгуулагч ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авах хүсэлтээ нийгмийн даатгалын байгууллагад цахимаар илгээсэн байна.</p> <p>Түүнчлэн төрийн цахим үйлчилгээний E-Mongolia нэгдсэн порталаар 12 төрлийн лавлагаа тодорхойлолт, үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд эдгээрээс 5 төрлийн лавлагаа тодорхойлолт нь англи хувилбараар гарч байна.</p> <p>Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 232 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй өгөгдлийн жагсаалт", Засгийн газрын 2022 оны 200 дугаар тогтоолоор баталсан "Мэдээлэл хариуцагчаас нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхэд тавигдах шаардлага, ашиглах нөхцөл, журам"-ын дагуу 2022 оны 4, 2023 оны 1, 2, 3 дугаар улирлын 16 нэр төрлийн нээлттэй мэдээллийг тус бүр дөрвөн форматаар хувирган ЗГХЭГ-ын www.opendata.gov.mn болон НДЕГ-ын www.ndaatgal.mn веб сайтуудад цаг тухай бүрд нь байршуулав.</p>	
НИЙТ ДУНДАЖ ҮНЭЛГЭЭ					92.2	